



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/412

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтууд болон "Гаүли ҮЦК" ХХК-ийн 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 24/53 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүн "Гаүли ҮЦК" ХХК-ийн ажилтан Ц.Баярмаагийн нэр дээрх GAUL.TSB нэртэй үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг хааж, тус компанийн ажилтан С.Энхзул -д шилжүүлэн олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан ажилтанд Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба (Ч.Эрдэнэболор)-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЦОГТБАЯР

1524030005